



Thomas Jefferson Middle School

Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа суралцаж байна.

Jefferson Middle School сургуулийн сурагч, тэдний гэр бүлийнхэнд мэнд хүргэе,

Jefferson Middle School-ийн 2019-20 оны хичээлийн жил нь 2019 оны 8-р сарын 29-ны Пүрэв гарагт Танилцах арга хэмжээ, 2019 оны 9-р сарын 3-ны Мягмар гарагт сургуулийн анхны өдрөөр эхлэхэд ердөө хоёрхон долоо хоног үлджээ гэдэгт итгэмээргүй санагдаж байна. Alice West Fleet бага сургууль шинэ байранд ороход бид бага ангийн сурагчдаа угтан авч, 2019 оны 8-р сарын 19-ний долоо хоногт Jefferson сургуулийн багш ажилтан ажилдаа эргэн орохыг тэсэн ядан хүлээж байна. Эдгээр өдрүүд ойртож байгаа тул бид шилжилтийн үеийг хүндрэл бэрхшээлгүй давахаар бүхий л арын ажлыг амжуулан, завгүй ажиллаж байна.

Миний бие TJMS сургуулийн урд талын төв хаалга, мөн ангиудад зориулсан орох хаалгыг дахин нээж байгааг зарлаж байгаадаа баяртай байна! Сургуулийн автобус манай төв орох хаалганы дэргэдэх шинэ автобусны эгнээнд сурагчдыг буулгаж, суулгах болно. Мөн S. Old Glebe Road гудамжинд Alice West Fleet бага сургуультай зэрэгцээ эцэг, эх, асран хамгаалагчдын хүүхдээ буулгаж суулгах шинэ эгнээ бий. Сурагчид ангидаа хамаарах хаалга руу явахдаа автобус болон эцэг эхийн буулгаж суулгах талбайгаас эхэлсэн явган хүний замыг ашиглана. Унадаг дугуйтай сурагчид дугуйгаа түгжихдээ урд төв хаалганы ойролцоо байрладаг дугуйны зогсоолыг ашиглаж болно. Сургууль дээр ирсэний дараа сурагчид сурдаг ангид нь хуваарилсан хаалгаар сургуулийн байранд нэвтрэн орно:

- » 6^р анги – 17-р хаалга
- » 7^р анги – 16-р хаалга
- » 8^р анги – 15-р хаалга

Хичээл тарахад сурагчид тухайн ангид хуваарилсан хаалгаараа гарна.

Сурагчдын гэр бүл хичээлийн жилийн эхний өдөрт бэлтгэхэд нь туслах зорилгоор бид [2019-20 оны хичээлийн жилд Thomas Jefferson дунд сургуулийн сурагчдын сургуульдаа ирэх, тарах журмыг](#) боловсруулахаар Арлингтоны улсын сургуулийн тээврийн газар, Арлингтон каунтигийн тээврийн хэлтэстэй хамтарч ажиллаж байна. Бид энэхүү иж бүрэн баримт бичиг, бусад мэдээллийг аль болох эрт [онлайнаар](#) уншиж танилцахыг танд зөвлөж байна.

Өөрийн зүгээс [Эцэг эх, багшийн холбоо](#) (ЭЭБХ), Jefferson сургуулийн нийт хамт олонд дэмжлэг туслалцаа үзүүлж байдаг тань талархаж буйгаа илэрхийлье. Бид 2019-20 оны хичээлийн шинэ жилээ амжилттай угтахын тулд зуны үлдсэн долоо хоногт сурагчид, тэдгээрийн гэр бүл, ажилтнуудтайгаа хамтран ажиллахаар зорьж байна.

Захирал Кейша Боган

keisha.boggan@apsva.us



JEFFERSON ДУНД СУРГУУЛИЙН

2019-20 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ШИНЭ МЭДЭЭЛЭЛ

Хичээлийн эхний өдөр сурагчид гэрээсээ гарах тэр минутад эхэлдэг тул сурагч автобусаар явах, алхах, дугуй унах эсэхээс үл хамааран хүрэх замаа урьдчилан төлөвлөж, турших нь гэр бүлүүдийн хувьд чухал юм. Хэрхэн зорчихоо төлөвлөхөд тань туслахын тулд энэ 2019-20 оны Тээвэрлэлтийн шинэ мэдээлэлд [Сурагчдын ирэх, тарах журмын](#) гол мэдээлэл, Jefferson дунд сургуульд ирэх, сургуулиас явахтай холбоотой зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл, зорчих арга хэлбэрээр ялгасан тодорхой мэдээлэл, бүх хүмүүст зориулсан тээврийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зөвлөгөө бий:

Сургуулийн автобус

Jefferson сургуулийн автобусаар зорчих бүсэд оршин суудаг бүх сурагчийг ([автобусаар зорчих бүсийн зургийн](#) тодруулсан хэсгийг үзээрэй) зөөх хуваарь гаргаж, сурагчдыг сургуулийн автобусанд суухыг зөвлөж байна.

- 2019-20 оны хичээлийн жилд сургуулийн автобусны хуваарийг гэр бүлүүдэд 8-р сарын 22-ны Пүрэв гарагаас өмнө илгээнэ. Мөн [ParentVue](#) порталд автобусны хуваарийг тавих болно.
- Гэрийнхээ ойр орчмын сургуулиудаас шилжсэн Jefferson сургуулийн сурагчдыг Jefferson сургуулийн бүс доторх "төвлөрсөн цэг" бүхий байршил эсвэл ойролцоох автобусны зогсоолуудад хуваарилж байна. Сурагчдыг гэртэй нь хамгийн ойр байрлах цэгт хуваарилна. Төвлөрсөн цэгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг [онлайнаар](#) авах боломжтой.
- 2019-20 оны хичээлийн жилийн APS сургуулийн автобусаар тээвэрлэх тухай ерөнхий мэдээллийг [онлайн](#) хэлбэрээр өгсөн.

- Jefferson сургуулийн автобус сургуулийн байрны баруун хойд буланд байрлах автобусны тойрогт төв талбайн урд сурагчдыг буулгаж, хүлээж, суулгана. [Сурагчдын ирэх, тарах журмын 4-р хуудасны А газрыг зургийг харна уу.](#)
- Дэлгэрэнгүй мэдээллийг Jefferson сургуулийн [Сурагчдын ирэх, тарах журмын](#) **Сургуулийн автобусны** (2-р хуудасны) хэсгээс үзнэ үү.

Алхах/Унадаг дугуй унах

Автобусны үйлчилгээнд хамрагдаагүй ([автобусаар зорчих шалгуурын бүсийн зургийн](#) ягаан хэсгийг үзээрэй) Jefferson сургуулийн ойр хавьд амьдардаг сурагчдыг алхаж эсвэл унадаг дугуй унаж сургуульдаа ирж очихыг зөвлөж байна. Төлөвлөхөд тань туслах зарим мэдээлэл энд бий:

- Тодорхой зааврыг [Сурагчдын ирэх, тарах журмын](#) (1-р хуудасны) **Сургуульдаа алхаж, унадаг дугуйгаар ирэхтэй** холбоотой хэсгийг үзнэ үү.
- Сургуулийн талбайн олон хэсэгт унадаг дугуй байрлуулах цэг бий. [Сурагчдын ирэх, тарах журмын](#) 4-р хуудсанд буй А газрын зургаас унадаг дугуй байрлуулах цэгийн байршлыг харна уу.

Гэр бүлийн тээврийн хэрэгсэл

APS сургууль уруу явах, сургуулиас ирэх бүх боломжийг судалж, тээврийн эрүүл, ногоон арга хэлбэрийг аль болох түлхүү ашиглахыг айл өрхөд зөвлөж байна. Хэрэв та автомашин жолоодох хэрэг гарвал дараах зүйлийг анхаарна уу:

- South Old Glebe Road гудамж дагуу эцэг эхийн автомашин дараалалд зогсож, сурагчдыг буулгаж суулгана. [Сурагчдын ирэх, тарах журмын](#) 5-р хуудасны В газрыг зургийг харна уу.
- Эцэг эхчүүд хүүхдээ буулгах суулгахдаа ЗӨВХӨН замын хөвөөний дагуу болон буулгаж, суулгах зориулалтын бүсэд зогсох хэрэгтэй. Сурагчид автомашинаас буухдаа машин зам руу гарахыг зөвшөөрөхгүй.
- Эцэг эхчүүд боломжтой бол хүүхдүүдээ нэг автомашинаар хамтран зөөж эсвэл сургуулийн ойролцоо буух, суулгах цэгийг олох замаар сургууль эхлэх, тарах үеэр түгжрэлээс зайлсхийх/бууруулах боломжтой (олон эцэг эх 2017-19 онд барилгын ажлын үеэр ингэж байсан).
- **Зочдын зогсоол:** Сургуулийн байранд хурдан ороод гарах (хүүхдээ авах эсвэл юм өгөх зэрэг) эсвэл уулзалт, сургуулийн арга хэмжээнд оролцох эсэхээс үл хамааран дараах зогсоолыг ашиглана уу. Өглөө 9 цагаас өмнө 2nd Street гудамж эсвэл тэр хавьд, мөн S. Old Glebe Road гудамжинд 09:00-өөс 14:00 цагийн хооронд машинаа тавина уу. Хэрэв зай байвал зочид 16:00 цагаас хойш гаражид машинаа тавьж болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зогсоол Thomas Jefferson дунд сургуулийн театрын талд бий. Үүнээс гадна теннисний талбайтай зэрэгцээ нийтийн зогсоол бий.
- Jefferson сургуулийн [Сурагчдын ирэх, тарах журмын](#) **Хувийн автомашинаар буулгаж, суулгахтай холбоотой хэсэгт** (2-3-р хуудасны) чухал зааврыг тайлбарласан.

Тээвэр, аюулгүй байдлын тусламж

Сурагчид, тэдний эцэг эхэд туслахын тулд Jefferson сургууль дараах байгууллагаас тусламж авна:

- Арлингтон каунтигийн цагдаагийн хэлтсийн ажилтан энэ жил дахин South Old Glebe Road, South 2nd Street гудамжны уулзвар дээр өдөр бүр ажиллаж, сурагчид сургууль дээрээ ирэх, мөн тарах үед замаар хөндлөн гарахад тусална.
- Манай сургуулийн Тээврийн зохицуулагч Jeremy Siegel-тэй 703-228-5904 дугаараар холбоо барьж болно.

Хууль сахиулах байгууллагын дэмжлэг

APS тээвэрлэлтийн аюулгүй байдлын хэрэгцээг урьдчилан төлөвлөх, хангах зорилгоор Арлингтон каунти цагдаагийн газартай хамтран ажиллаж байна:

- Хичээл эхэлсэн болохыг жолооч нарт анхааруулах үтгэ бүхий олон тэмдэг тэмдэглэгээг каунти даяар байрлуулах (Арлингтон каунти яармагийн дараа 8-р сараас эхлэн)
- Хичээл эхлэхээс өмнө хууль сахиулах арга хэмжээг хэрэгжүүлэх (8-р сараас эхлэн)
- Хичээл эхлэх эхний долоо хоногт гол үүлзваруудад цагдаа нарыг ажиллуулах

Тээвэрлэлтийн аюулгүй байдлын зөвлөгөө

Сургууль руу болон сургуулиас явах, ойртохдоо дараах зүйлийг санаарай:

- Жолоодох, алхах, унадаг дугуй унах үл хамааран сонор сэрэмжтэй байж, анхааралтай байх
- Хөдөлгөөнт төхөөрөмжөө салгаж, чихэвчийг авч байх
- Тэмдэглэгээтэй гарцаар гарах
- Хөдөлгөөн зохицуулах бүх тэмдэг, гэрлэн дохиог дагаж мөрдөх

Зорчих бүх хэлбэртэй холбоотой [аюулгүй байдлын зөвлөмж, тээврийн мэдээ мэдээллийн бүрэн жагсаалтыг](#) [Сургуульдаа аюулгүй хүрч очих маршрутын тухай АУС-ын вэб](#) хуудаснаас үзээрэй.

АУС, Сургуульдаа аюулгүй хүрэх сэдэв бүхий аюулгүй байдлын нэмэлт материалыг хичээл эхэлсний дараа [Peachjar-р](#) дамжуулан илгээнэ.

Тээвэрлэлтийн аюулгүй байдлын мэдээ, мэдээлэл

Аюулгүй байдал бол бидний хамгийн чухал зүйл юм. Дараах мэдээллийг авах боломжтой бөгөөд бид та бүхэнд ашиглахыг зөвлөж байна:

Онлайн мэдээлэл ([Jefferson сургуулийн вэбсайтаас](#) авах боломжтой)

- [Jefferson сургуулийн автобусаар зорчих эрхийн газрын зураг](#)
- [Сургуулийн автобусны буулгах/А ГАЗРЫН ЗУРАГ](#)
- [Хотхон руу алхах/унадаг дугуйгаар очих, дугуйгаа тавих байршил /А ГАЗРЫН ЗУРАГ](#)
- [Гэр бүлийн тээврийн хэрэгслийн буулгах/суулгах цэгийн газрын зураг /Б ГАЗРЫН ЗУРАГ](#)
- [Сургуульд аюулгүй хүрч очих маршрутын \(САХОМ\) мэдээлэл](#)
 - Явган хүний аюулгүй байдал
 - Унадаг дугуйн аюулгүй байдал
 - Алхах, сургуулийн автобусны мэдээлэл (дунд сургуульд зориулан өөрчлөх боломжтой)
 - Унадаг дугуй, Галт тэрэгний мэдээлэл (дунд сургуульд зориулан өөрчлөх боломжтой)
 - Санхүүжүүлэх боломж (SRTS бага хэмжээтэй тэтгэлэг)

Хэрэгсэл, хангамжийн зүйлс

Ажилтнууд / сайн дүраараа ажиллах эцэг эхэд зориулсан цацруулагчтай хантааз

ShareVaRoad гэр бүл / ажилтнуудад зориулсан халаасны гарын авлага [англи](#), [испани](#) хэлээр

Урьдчилсан бэлтгэл

2019-2020 оны хичээлийн жилийг угтан авч, бүх сурагчид маань Jefferson сургуульдаа аюулгүй, цагтаа ирэх нөхцөл боломжийг хангаж, Alice West Fleet бага сургуулийг нээхэд дэмжлэг үзүүлэхийн тулд APS гэр бүл, ажилтнууд, иргэдтэй хамтран ажиллахаар зорьж байна.

Бид сургуульд ирэх, тарах журмыг боловсронгуй болгож, сургуулийн автобус болон талбайг хамтран ашиглахад туслах зорилгоор Fleet бага сургуулийн удирдлагууд, ажилчид, сурагчдын гэр бүлийнхэнтэй нягт хамтран ажиллаж байна. Төлөвлөх зорилгоор Fleet сургуулийн хичээлийн хуваарийг анхаарна уу:

Сургуулийн энгийн өдөр: 09:00 – 15:41

Эрт тарах: 13:26

Хоёр цаг хоцорч эхлэх өдөр: 11:00

Уртасгасан өдрийн хөтөлбөр:

Өглөө 07:00 – 08:45

Үдээс хойш 15:41 – 18:00

Хичээлийн дараах дугуйлан/Дамжаа: 15:45 – 16:45

Аюулгүй байдлаа хангахад бид бүгдээрээ хариуцлага хүлээж, урьдчилан бэлтгэх нь маш чухал болохыг бидний зүгээс онцлон анхааруулж байна. Та болон танай хүүхдийн хувьд юу хамгийн оновчтой болохыг та мэдэх тул дараа дараагийн долоо хоногт сурагчийн тээвэрлэлттэй холбоотой эдгээр мэдээ мэдээллийг ашиглан явган явах, унадаг дугуй унах эсвэл сургуулийн автобусаар зорчих эсэхийг үл харгалзан хүүхдийнхээ маршрутыг гаргахыг бид танд зөвлөж байна.